ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 3
1.2. Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил: 3
1.3. Уурхайн нээлт, ашиглалт явуулах дараалал 5
1.4. Уурхайн үндсэн үйл ажиллагаанууд, тоног төхөөрөмж 6
1.5. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа 7
1.6. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц 8

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 13

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 15

3.1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж 15
3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим 15

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 25

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 26
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 27
4.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн 27
4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 29
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 29
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 29
4.7. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө 30
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 30
4.9. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь 30
4.10. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр 31
4.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 32
4.12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 33

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд 6
Хүснэгт 2. Уурхайн жилд ажиллах хоногийн тооцоо 7
Хүснэгт 3. Цахилгаан хэрэглэгчдийн тооцооны чадал 9
Хүснэгт 4. Төслийн усан хангамжийн тооцоо 11
Хүснэгт 5. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим 15
Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах 18
Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл 22
Хүснэгт 8. Гол сөрөг нөлөөлөл 23
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал 26
Хүснэгт 10. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийн хүрээнд хийгдэх ажил 27
Хүснэгт 11. Усан хангамжийг сайжруулах арга хэмжээ 29
Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 29
Хүснэгт 13 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 29
Хүснэгт 14. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал 30
Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал 30
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал 31
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 32
Хүснэгт 18. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал 33
Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн товчоо 33

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил 4
Зураг 2. Ордоос Улаанбаатар-Алтанбулагийн чиглалийн автозам хүртэлх зам 8
Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн нөлөөллийн бүс 24


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“СУУРЬ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, Өөрийн байр-00
3	Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших “Дархан толгой” нэртэй барилгын чулууны орд
4	Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт	а. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9911010080 Улсын регистрийн дугаар: 2041588 Улсад бүртгүүлсэн: 2006.05.18 б. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-005806 Олгосон огноо: 2007.01.29
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол	Талбай: 46 га Газар зүйн солбилцол: (L-48-11) 1. 105° 58’ 11.12” 49° 31’ 0.97” 2. 105° 58’ 45.12” 49° 31’ 0.97” 3. 105° 58’ 45.12” 49° 30’ 38.97” 4. 105° 58’ 11.12” 49° 30’ 38.97”
6	Ордын тоосгоны шаврын анх батлагдсан геологийн бодитой (В) нөөц	3571.8 мян.м^3
7	Үйлдвэрлэлийн нөөц	357.0 мян.м^3
8	Жилийн хүчин чадал	Олборлолт: 18.0 мян.м^3
9	Ордын ашиглалтын хугацаа	36.3 жил
10	Төслийн нийт хөрөнгө оруулалт	1724.94 сая.төг

1.2.Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

“Дархан толгой” барилгын чулууны орд нь Улаанбаатар хотоос хойд зүгт 240 км, Дархан-Уул аймгийн төвөөс зүүн хойш 4.0 км, Улаанбаатар, Дархан, Сүхбаатарын цардмал авто замаас 1.5 км MV-005806 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 46 га талбайд оршино.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.3.Уурхайн нээлт, ашиглалт явуулах дараалал

Уурхайн нээлт

Уурхайн талбайн нээлтийн ажлыг 1967 онд хийсэн ба өнөөгийн байдлаар ордын А, В блокийн талбайн урд ба хойд талаар сайжруулсан шороон зам хийсэн байдаг. Уурхайгаас боловсруулах үйлдвэр хүртлэх зай 1.5км, олборлолтын доголын тоо 11, өндөр нь h=5м болно.

Төслөөр +854 м түвшин хүртэл нэмэлт траншейгүйгээр олборлолтын ажлыг хийх ба +849-+819м түвшинд суух үед гадаад траншейг тухай бүрд нь нөөцийн блокийн урд хэсэгт тавигдсан замын дагууд хийхээр байна. Газрын гадаргуугийн налуу нь ашигт малмалыг нээж олборлох үед тээврийн хэрэгсэл саадгүй явах боломжтой. Түвшингүүдийг нээхийн тулд экскаватор, өөрөө буулгагч автосамосвалын хослолоор газрыг ухаж тээвэрлэн орох зам засна.

Олборлолтыг ордын төв хэсэг болох нөөцийн В-III блокоос толгойн өндөр хэсгийг намсгаж тэгш түвшингийн гадаргууг аль болох их гаргах үүднээс өмнө нь ил уурхайгаар ашигласныг цааш үргэлжлүүлэн хийнэ.

Уурхайн ашиглалт явуулах дараалал

Барилгын чулууг бутлан ангилж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа нь дараах үндсэн ажилбаруудаар гүйцэтгэгдэнэ.

Үүнд:

БАРИЛГЫН ЧУЛУУГ БУНКЕРТ ӨГӨХ ► БАРИЛГЫН ЧУЛУУГ БУТЛАХ ► БАРИЛГЫН ЧУЛУУГ АНГИЛАН ЯЛГАХ ► ЭСЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.

.

1.4.Уурхайн үндсэн үйл ажиллагаанууд, тоног төхөөрөмж

Хөрс хуулалт, овоолго болон агуулах

Хайгуулын ажлын үр дүнд “Дархан толгой” барилгын чулууны ордын хөрсний дундаж зузааныг 0.39 м гэж тогтоосныг үндэслэн хөрс хуулалтанд Shantui SD16E маркийн бульдозер ашиглахаар төлөвлөлөө.

Олборлолтын үед уурхайн талбайн хил хязгаар доторх А-II блокод ногдох хэсэгшлийн хуулах хөрсний хэмжээ 36345 м^3, олборлох барилгын чулууны нөөц 994664 м^3 болно.
В-III блокийн талбайн хил хязгаар доторхи хуулах хөрсний хэмжээ 255768 м^3, уурхайн хил хязгаар дотор олборлолтод өртөх нөөц 3308203 м^3 байна. Дархан толгой барилгын чулууны ордыг А, В блокийн хүрээнд нийт хуулах хөрс 292113 м^3 болно. Харин 1967 оноос хойш ашиглалт явуулахдаа нөөцийн блокийн хил дотор байршуулсан овоолгыг инженерийн ажил гэж нэрлэн хөрс хуулалтын ажилд нэмж тооцоолов. Тухайлбал : А-II блокод 2664 м^3, В-III блокод 21614м^3, нийт 24278 м^3 хөрсийг дахин ачна. Эндээс ордын хэмжээнд хуулах нийт хөрс 316392 м^3 байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 1:13.6 байна.

Уурхайн үндсэн тоног төхөөрөмж

Ил уурхайн хэлбэр хэмжээ, орон зай, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцлүүдийг үндэслэн дараах технологи, механикжуулалтын бүтэц нь хөрс хуулалт, овоолго, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзлээ.

Хүснэгт 1. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

д/д	Тоног төхөөрөмж	Марк	Хүчин чадал	Тоо, ш
1	Экскаватор	Hyundai 2900LC3	1.1 м^3	1
2	Автосамосвал	Rowor	10 тн	1
3	Утгуурт ачигч	LONGGONG LLG	м^3	1
4	Туузан дамжуулагч	B-600 L-13,17,22,25,27		5
5	Хацарт бутлуур	PE-600*900		1
6	Цохилтод бутлуур	PFY1210		2
7	Доргиурт тэжээгүүр	ZSW 380-95		1
8	Хүлээн авах бүнкер			
9	HOWO SINOTRUK	3256M	25тн	1

1.5.Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Уурхайн ашиглалтын горим

Уурхай нь жилд 125.0 мян.м^3/жил барилгын чулуу олборлох ба 30.57 мян.м^3 хөрс хуулалтын ажил хийх ба жилд 155.57 мян м^3 уулын цулыг тэслэж ачих хүчин чадалтай.

Тус ордын +819-ээс түвшнээс дээш тооцсон уурхайн үйлдвэрлэлийн нөөц 4537.5 мян.м^3, төсөлд тооцсоноор 125.0 мян.м^3/жил чулуу олборлоно гэж үзвэл, энэ нөөцийг 36.3 жил ашиглана.

Үйлдвэрлэлийн ажиллах горим, ашиглалтын хугацааг уурхайн жилийн хүчин чадлаас хамааруулан тооцоолов. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улиралд (4-р сарын 1-наас 11-р сарын 1 хүртэл) 7 сарын хугацаанд жилд 153 хоног, хоногт 1 ээлж, ээлжинд 7 цагаар ажиллана.

Ажилчдын баяр ёслолын үеийн болон амралтын үеийн амрах хугацааг МУ-ын хөдөлмөрийн хуулийн дагуу уурхайг эзэмшигч компаний захирлын тушаалаар зохицуулна.

Хүснэгт 2. Уурхайн жилд ажиллах хоногийн тооцоо

№	Утга	Үзүүлэлтүүд
1	Жилд ажиллах хуанлийн хоног	214
2	Засварт зогсох хоног	10
3	Амралт, баяр ёслолын хоног	42
4	Цаг агаарын болзошгүй саатлын хоног	9
5	Жинхэнэ ажиллах хоног	153
6	Хоногт ажиллах ээлж	1
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	7
8	Уурхайн ээлжийн тооцооны бүтээл	364 м^3/ээлж буюу 952 тн /ээлж

Уурхайн хөрс хуулалт

Хайгуулын ажлын үр дүнд “Дархан Толгой” барилгын чулуун ордын хөрсний дундаж зузааныг 0.6 м гэж тогтоосныг үндэслэн хөрс хуулалтанд Экскаватор R2900LC-7 маркийн экскаватор ашиглахаар төлөвлөлөө.

Ордыг ашиглах уул техникийн нөхцлөөс үзэхэд хөрс хуулалтын ажил харьцангуй бага бөгөөд уурхай жилд дунджаар 30.57 мян.м^3 хөрс хуулна.

Барилгын чулуу олборлолт

Барилгын чулууны олборлолтын ажлыг хөрсний үе давхаргыг хуулж тодорхой хэмжээний шаврын нөөцийг нээсэн талбайгаас экскаватор болон автосамосвалын хослол бүхий тээвэртэй ашиглалтын системээр явуулна. Олборлолтын доголын өндөр 4м нийт доголын өндөр 8м.

Барилгын чулууны давхаргыг R2900LC-7 маркийн 1.2 $м^3$-ийн багтаамжтай утгуур бүхий экскаватор ашиглан олборлох ба автосамосвалаар тээвэрлэн ялгах үйлдвэрийн хүлээн авах бункерын дэргэд хүргэнэ.

1.6.Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.6.1.Автозам

Дархан толгой барилгын чулууны орд нь дэд бүтэц сайн хөгжсөн Дархан сумын нутагт орших ба Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн автозамаас 1.5км зайд оршино. Харин бутлан ангилах үйлдвэр нь дээрх авто замын яг дэргэд оршдогоороо онцлогтой. Зам харилцааны хувьд маш тааламжтай нөхцөлтэй болно.



Зураг 2. Ордоос Улаанбаатар-Алтанбулагийн чиглалийн автозам хүртэлх зам

1.6.2. Уурхайн цахилгаан хангамж

Цахилгааны гол хэрэглэгч нь 224кВт суурилагдсан чадалтай бутлан ангилах үйлдвэрийн төхөөрөмжөөс гадна, гэрэлтүүлэг, засварын жижиг цех, захиргаа аж ахуй, цайны газар зэрэг ахуйн хэрэглээний обьектууд ажиллана.

Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн тооцооны хүчин чадлыг дараах байдлаар тооцож дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Цахилгаан хэрэглэгчдийн тооцооны чадал

№[1]	Цахилгаан хэрэглэгчдийн нэрс	Суурилагдсан чадал		Чадлын коэффи-циент, cos φ	Тооцооны чадал кВт	Ажиллах цаг	Цахилгааны хэрэглээ, мян.кВт.цаг
		Нэгж	Бүгд				
1	Бутлан ангилах цех	кВт	224	0.8	172	764	131.4
3	Засварын цех	кВт	8	0.8	6.4	229	1.5
4	Гэрэлтүүлэг ахуйн хэрэглээ	кВт	2	0.6	1.2	2160	2.6
4	Цайны газар	кВт	2	0.7	1.4	516	1
5	Бусад	кВт	2	1	1	800	1
	нийт		238		182		137.5

Дээрх үзүүлэлтүүд болон үйлдвэрийн хэтийн төлөвийг харгалзан үзэж цахилгааны тоног төхөөрөмжүүд, цахилгаан дамжуулах агаарын шугам, кабель зэрэг нь дээр дурьдсан төслөл гүйцэтгэлээр дараах байдлаар сонгогдсон байна.

-Хүчний трансформатор S11-M-250/15-250кВА

-Цахилгаан дамжуулах агаарын 15 кв-ийн шугамд, АС-50 - 50м

-0.4 кВ-ийн зөөврийн цахилгаан дамжуулах кабель - 40м зэрэг

4-3. Дулаан хангамж

“СУУРЬ” ХХК-ийн үйлдвэрлэлийн талбайд орших захиргаа аж ахуйн барилга, цайны газар, засварын цех, харуулын байр зэрэг байгууламжууд нь хүйтэн улиралд халаалт авах шаардлагатайгаас гадна ажиллагсадын халуун ус, угаалгын газарт халуун ус ашиглагдана. Эдгээр байгууламжууд нь 1970-1980 оны үед баригдаж ашиглалтад орсон 2 давхар барилгад бүгд төвлөрсөн ба дулаан хангамжийн асуудлыг бага оврын уурын зуухаар бүрэн шийдсэн байдаг.

Тус компанийн бага оврын уурын зуух хоногт дунджаар нийт 100 кг нүүрс түлдэг гэвэл жилд 20 тн нүүрс шаардагдана.

1.6.3. Ус хангамж:

а. Уурхайн ус шүүрүүлэлт

Дархан толгой барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах тул газрын доорх ус, агаар хур тунадаснаас орж ирэх усны тоо хэмжээг зайлшгүй тодорхойлно. Ер нь ил уурхайд орж ирэх усны тоо, хэмжээ, тооцоог тодорхойлохдоо ордын гидрогеологийн нөхцөл, байгалийн болон уул техникийн олон хүчин зүйл дээр тулгуурлана. Үүнд:

- Ил уурхайн орчинд том гол, мөрөн зэрэг урсгал ус, нуур, цөөрөм, зэрэг тогтмол ус байгаа эсэх
- Хүчтэй усжилт бүхий тектоникийн том хагарал, олон жилийн цэвдгийн байдал
- Газрын гадаргуугын хотгор, гүдгэрийн хэв шинж, хэрчигдэлд орсон байдал, нарийн хавцал, газар доорх усны тэжээгдлийн муж, түүний тархалтын хэмжээ
- Уст давхрагуудын шинж чанар, түүний хил, заагийн нөхцөл, даралттай ус, тэдгээрийн хоорондын холбоо зэрэг гидрогеологийн болон геологийн олон хүчин зүйлс
-Талбайн шинжтэй тархсан томоохон уст үе байхгүй.

Тус орд газарт гидрогеологийн тусгайлсан судалгаа хийгдээгүй байна. Харин геологи хайгуулын үед өрөмдсөн 70 м гүн цооногоос ус илрээгүй тул газрын гүний усыг байхгүй гэж тооцов.

б. Гадаргуугийн усны хамгаалалт

Уурхайд цугларах ус нь зөвхөн хур тунадасны дүнд хуримтлагдана. Ордын район дахь уурхайн талбай нь харьцангуй өндөрлөгт оршдог тул олборлолтонд хүндрэл учруулхааргүй байна.

Харин гэнэтийн үер, хур бороо орсон үед уурхайн ёроолд ус тогтож болзошгүй ба ийм үед ус таталтын ажлыг ил аргаар уурхайн ёроолд ил зумпф байгуулж усаа насосоор татаж зайлуулна.

в. Уурхайн технологийн усан хангамж

Дархан толгой барилгын чулууны ил уурхай, бутлан ангилан үйлдвэрт технологийн зориулалтаар ус ашиглахгүй ба зөвхөн хүрээлэн байгаа орчинд шороо тоос босгохгүй байхын тулд автозамыг байнга услана. Усалгааны ажлын тооцоог II-16-1д хийсэн байгаа тул дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

г. Ахуйн хэрэглээний усны тооцоо

Дархан толгой барилгын чулууны ил уурхайд шаардгадах ус нь уурхай, үйлдвэрт ажиллагсдын ахуйн хэрэглээнд зарцуулагдана. Уурхайд нийт 21 хүн ажиллана.

Уурхайн сууринд:

Ажиллагсдын түр амрах сууц – 1 ширхэг

Халуун усны газар – 1ширхэг

Ажилчдын гуанз – 1ширхэг тус тус байна.

Төслийн усан хангамжийг Дархан - Уул аймгийн төвд байх төвлөрсөн усан хангамжын худгаас худалдан авах болно.

Хүснэгт 4. Төслийн усан хангамжийн тооцоо

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, $м^3$	Жилийн усны хэрэглээ, тн	Норм
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	80 л/хоног	21 хүн /нийт ажилчин/	184	1.68	309.12	А/301 дугаар тушаалын 12-р хавсралт
2	Зам талбай	2 $л/м^2$	1000 $м^2$	нийт 52 удаа	2.0	104.0	А/301 дугаар тушаалын 13-р хавсралт
3	Ногоон байгууламж	40 л	100 ш	15 удаа	4.0	60	А/301 дугаар тушаалын 11-р хавсралт
Нийт дүн					**7.36**	**473.12**	

1.6.4. Барилга байгууламж:

Ажилчдын тосгон дахь барилга байгууламжууд

Уурхай ба бутлан ангилах үйлдвэр нь улирлын чанартай ажиллана. Уурхайн болон үйлдвэрийн ажиллагсад Дархан - Уул аймгийн төв дэх гэрээсээ ажилдаа явах боломжтой. Иймд захиргаа аж ахуйн байр, ажиллагсдын амрах байр, цайны газар, халуун ус, ариун цэврийн өрөө тус тус 1 ш байна.

Үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламжууд

Үйлдвэрлэлийн дараах барилга байгууламж, объектууд байна: Үүнд:

- бутлан ангилах үйлдвэр
- засварын цех
- техникийн гарааш
- уурхайн өндөр хүчдлийн шугам, трансформатор
- Сэлбэг материалын агуулах
- харуулын байр

Энэ бүхэн нь хуучнаар Дархан - Уул аймгийн чулуун карьерийн үйлдвэр гэж байх үеийн бааз суурь дээр байдаг учир бүрэн шийдвэрлэгдсэн байдаг.

Уурхайн засварын хэсэг нь дотоод шаталтын хөдөлгүүртэй тоног төхөөрөмжийн урсгал ба үндсэн засвар, техник үйлчилгээний ажлуудыг хийнэ. Мөн цахилгаан хөдөлгүүр, генератор, цахилгаан аппарат, хэмжих багаж хэрэгсэл, тоноглолын техникийн үйлчилгээ, урсгал засварыг гүйцэтгэнэ.

Материал, сэлбэгийн агуулах нь уурхайн үндсэн тоног төхөөрөмж, машин механизм, техник тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бусад туслах материалуудыг хадгалах түгээх зориулалттай. Зарим том оврын сэлбэг, эд ангийг гараашид тусгай талбайд хадгална.

1.7. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2025 онд тус уурхай нь 30.573 мян.м^3 хөрс хуулж, 125 мян.м^3 дайрга олборлохоор төлөвлөсөн байна. Үүнийг боловсруулж 0-5 дайрга 14.7 мян. м^3, 5-10 дайрга 38.8 мян.м^3, 10-20 дайрга 71.6 мян.м^3 бүтээгдэхүүн гарган дотоодын зах зээлд борлуулна. Тус онд 2.485 га нэмж өртөнө. Харин уурхайлалт нь газрын гүн рүү чиглэлд ухагдах тул нөхөн сэргээгдэх талбай байхгүй.

Уурхайн олборлолтонд нийт 10 га газар өртсөн ба 4 га газарт хөрсний овоолго үүссэн. 2025 онд 2.4 га талбайн хөрс хуулалт хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цаг уур: Ордын талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн нь 1-р сард -38°С, дулаан нь 7-р сард +33°С хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 230-300 мм-с хэтрэхгүй, түүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 30-15% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг. Салхины хурд өвөлдөө 5-9м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 10-30 см орчим байдаг.

Цэвдэгшлэлийн мужлалаар алаг цоог тархалттай бүс нутагт хамаарах боловч хайгуулын талбайд хийсэн шурф малталтын явцад цэвдэгшил ажиглагдаагүй. Өвөлдөө хөрсний хөлдөлтийн гүн дунджаар 2,5-3,0м-т хүрдэг.

Усан сүлжээ: харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт харъяалагдана. Байнгын урсгалтай гол, горхи нь талбайн баруун хойд хэсгээр зүүнээс баруун урагш урсах Туул гол юм. Хадан гарш бүхий толгод, хөндийн хэсгээр хагарал дагаж гарсан булгууд тохиолдох бөгөөд тэдгээр нь хур бороо элбэгтэй зуны саруудад усаар тэжээгдэж горхи үүсгэдэг.

Томоохон гол, нууруудын хөндийд жилийн ихэнх үед гадаргуугийн устай байдаг. Газар доорх усны түвшин хөндий газруудад гадаргууд харьцангуй ойрхон байдаг. Бидний хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд тэмдэглэгдсэн уст цэг байхгүй.

Ландшафт геохими: мужлалаар ордын талбай нь Хэнтийн уулархаг бүсэд хамаарагдана. Тус бүс нутаг ерөнхийдөө чулуурхаг хар хүрэн болон шаварлаг, элсэрхэг хөрстэй учраас ургамлын төрөл зүйл ихтэй байдаг. Хайгуулын талбай нь ан амьтан цөөн, ургамал тал хээрийн өвс ургамал голлоно. Харин Туул голоос хойш ургамал амьтны аймаг нь өөр болно.

Ургамлан бүрхэвч: Төслийн талбай 1510-1550 м-ийн үнэмлэхүй орчын газарт байрлана. Ургамалжилт-газарзүйн бүсчлэлээр Евроазийн шилмүүст ой, уулын нуга, хээрийн Их мужийн Дорнод Азийн дэд мужийн Монгол-дагуурын Их хошууны Өмнөд Хэнтийн дэд хошууны Өмнөд Хэнтийн нам уулсын тойрогт хамаарна.

Ургамлын бүлгэмдлийн хувьд шарилж-алаг өвст бүлгэмдэл тархсан. Ойролцоох талбайн хувьд ерөнхийдөө хүний нөлөөнд өртсөн боловч хуучин нийгмийн үед ашиглаж байсан далд уурхайн ам, дов сондуул их, далд уурхайн ухсан ам, нүх хооронд байгалийн төрхөөрөө байгаа талбай багагүй хэмжээтэй байна. Талбайн үйл ажиллагаа явуулж байсан хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн налуу, болсоо ам болон олборлолт явуулахаар ухаж байсан амуудын эргэн тойронд дахь газар талхлагдаж хөлийн газрын ургамлууд ургасан байна. Үүнд:

- ✓ Царван Artemisia sieveriana
- ✓ Шүлхий шарилж Artemisie dracunculus
- ✓ Ишгэн шарилж
- ✓ Цагаан лууль Chenopodium album
- ✓ Хар лантанз Hyoscyamus niger

Ашиглалт явуулаагүй талбай болон ам хооронд дараах ургамлууд ургасан байна. Үүнд:

- ✓ Үсхий нохойн хэл Panzeria lanata
- ✓ Чөдөр сэдэргэнэ Convolvulus arvensis
- ✓ Дэлхээ тогторгоно Kochia prostrata
- ✓ Арзгар согсоолж Heteropappus hispidus
- ✓ Долгионтсон гишүүнэ Rheum undulatum
- ✓ Толгодын бударга Salsola collina
- ✓ Галуун гичгэнэ Potentilla anserine
- ✓ Өмхий шимэлдэг Dracocephalum foetidum
- ✓ Замын таван салаа Platogo depressa
- ✓ Эмийн багваахай Taraxacum offinale
- ✓ Дурсгалжин ноцоргоно Myosotis moench
- ✓ Гашуун банздоо Saussurea amara
- ✓ Мөлхөө шээрэнгэ Silene repens
- ✓ Сүг цангуу Lepidium ruderale
- ✓ Дэрвээн хазаар өвс Cleistogenes soongorica
- ✓ Налчигар сүүт өвс Euphorbia humifusa
- ✓ Хорон дэрс Achnaterum splendes
- ✓ Сибирь өлөнгө Elymus sibirica
- ✓ Эгэл гоньд Carum carvi
- ✓ Цагаалин цахилдаг Iris lacteal
- ✓ Ширэг улалж зэрэг алаг өвс ургасан байна.

Амьтны аймаг: Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үед үүсэх дуу чимээний хэмжээг бага түвшинд байлгах, Холбогдох хуулийг нийт ажиллагсдад танилцуулан, уурхайг мал амьтанд аюулгүй байхаар ашиглах шаардлагатай.

Эдийн засаг, зам харилцаа: Дархан-Уул аймагт жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжиж байгаа билээ. Хувийн хөрөнгө оруулалтаар оёдол, архи спиртийн үйлдвэр, савхин эдлэл, талх нарийн боов, мах махан бүтээгдэхүүн зэрэг жижиг дунд үйлдвэрүүд болон Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг аж ахуйн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус аймаг нь зам, тээвэр, харилцаа холбоо, цахилгаан, дулааны эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарууд сайн хөгжсөн үйлдвэрлэл, соёл боловсрол, шинжлэх ухаанны томоохон төв учраас гадаад орнуудын муж, хот, компани, хувь хүмүүстэй харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж хамтран ажиллах хамгийн таатай нөхцөл бүрдсэн аймаг юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Суурь” ХК-ийн “Дархан толгой” нэртэй байрилгын төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, загварчлал, харьцуулсан судалгааны арга зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

3.2.1. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 5. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	**Шууд**	**Шууд бус**	**Өөрөө зохицуулагдах**	**Богино хугацааны**	**Урт хугацааны**	**Бүцаж нөлөөлөх**	**Буцалтгүй нөлөөлөх**	**Хүчтэй**	**Дунд зэрэг**	**Бага зэрэг**
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X		X			X
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X	X		
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X	X		
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	X				X		X		X	
Бэлчээрийн байдал	X				X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X		X	X		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Ундны усны чанар, хэмжээ	X									
Урсгал усны хэрэгцээ	X									
Агаарын бохирдол				X					X	
Хөрсний эвдрэл, бохирдол					X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		X								X
4. Байгалийн өнгө төрх, түүхи соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X				X		X		X	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X			X					X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X			X	X		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X			X					X	
Ажлын байр нэмэгдэх	X									X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X			X					X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X						X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				X		X		X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X			X		X				X
Хүчтэй салхи, уруйн үер	X			X			X	X		
Дүн	**19**	**3**	**0**	**9**	**10**	**1**	**14**	**5**	**10**	**8**

Болзошгүй шууд нөлөөлөл:

Хөрс хуулах, барилгын чулуу олборлох, зам гаргах үед хөрсний эвдрэл үүсэх, түүнд өртсөн ургамлан нөмрөг, биологийн төрөл зүйл устах, суларсан хөрс шороонооос агаарын бохидол үүсэх

- ✓ Байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүчтэй салхи, газар хөдлөл, үер зэрэг байгалийн гамшиг бий болох
- ✓ Усны нөөц тодорхой хэмжээгээр хомсдох
- ✓ Ажиллагсдын хайнга ажиллагаанаас гал түймэр гарах
- ✓ Хатуу, шингэн хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материал асгарснаас орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материалын ууршилтаас агаарын бохирдол үүсэх
- ✓ Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх

Болзошгүй шууд бус нөлөөлөл

- ✓ Барилгын чулуу олборлолтоос бичил биетэн, биологийн төрөл зүйлд нөлөөлөх
- ✓ Хөрс хуулалт болон олборлолтоос шалтгаалан хөрсний үржил шим алдагдах

Урт хугацааны нөлөөлөл

- ✓ Барилгын чулуу олборлолтоос үүдэн гарах урт хугацааны нөлөөлөл нь хөрсний эвдрэл, ургамлан нөмрөг устах зэрэг асуудал болно. Иймд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай хийх шаардлагатай.

Богино хугацааны нөлөөлөл:

Орчны дуу чимээ ихсэх, агаарын бохирдол түр хугацаагаар үүсэх, ус хэрэглээнээс цэвэр усны нөөц богино хугацаанд өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл үүнд хамаарна.

Эрчимтэй нөлөөлөл:

Нарийвчилсан үнэлгээний үр дүнгээс үзэхэд элс хайрга олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа нь элс хайрганы хольцын орд газрын хөрсний эвдрэл, агаарын бохирдол юм.

3.2.2. Төслийн байршил шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл:

“Суурь” ХХК-ийн барилгын чулуу олборлох төслийн үйл ажиллагааны үед уг уурхайн байршил, техник-технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг ”бага” “дунд” ”их” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Монгол орны нөхцөлд ил аргаар байгалийн эрдэс баялгийг олборлодог үйлдвэрүүдийн хувьд онц аюултай хүчтэй салхи, үер (хүчтэй аадар бороony дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай.

Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудал	**Нөлөөлөл байхгүй**	**Гол үр дагавар**		
		бага	**дунд**	**их**
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын гольдролыг эвдэж, өөрчлөх	X			
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	X			
Ой модыг огтлох, гэмтээх асуудал	X			
Түүх, дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	X			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	X			
Булаг шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	X			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, түүхий эдийг олзворлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			X	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			X	
Элс хайрга олборлох үед болон уурхайгаас гарах грунтын уснаас хамгаалах, хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой	X			
Гидравлик даралттай усны цоргоор гарах булингартай усыг тунгаах, урсгал усны чанарыг хамгаалах, хянах асуудал	X			
Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс, бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах			X	
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх				X
Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төрөлд тусгагдсан эсэх			X	
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	x			

Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл эвдрэл			X	
